

## МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ БА ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ (ХІХ ЗУУНЫ СҮҮЛЧ, ХХ ЗУУНЫ ЭХЭН ҮЕ)

*Л.Оюунгэрэл\**

ХІХ зууны сүүлч, ХХ зууны эхэн үед Монголтой ойролцоо цаг үед орчин цагийн хөгжил дэвшлийн замыг сонгож авсан улс орнуудаас гүйцэгдэхгүй болсон улс орон байхад Афганистан, Ирак, зэрэг уламжлалт нийгмийнх нь хүчин зүйлүүд өнөөдөр ч хөгжил дэвшилд нь саад болсоор байгаа олон улс байна. Монгол нь урьдын түүхтэйгээ харьцуулахад сүр хүч, газар нутгийн хувьд харьцуулашгүй жижиг болсон ч, 200 жил Манж Чин улсын колоничлол дор байх үетэйгээ харьцуулахад ганцхан зуунд орчин үеийн улс болж чаджээ. Энэ нь үе үеийн эх орончдын уйгагүй хүчин чармайлт байснаас гадна Монгол орны баялаг-мал сүрэг, байгалийн нөөц, монгол хүний оюун ухаан, хөдөлмөр зүтгэлийн ач юм.

Дэлхийн их гүрнүүдийн хувьд Монголыг сонирхох сонирхол нэгдүгээрт, стратегийн буюу цэрэг-улс төрийн ач холбогдол, хоёрдугаарт, мал аж ахуй ба байгалийн баялаг, түүнээс гадна олон хүн шинээр суурьшиж газар тариалан, үйлдвэрлэл, ялангуяа уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх боломжтой өргөн уудам нутаг зэрэг эдийн засгийн хүчин зүйлээр тодорхойлогдож байгаа. Өнгөрсөн зууныг өнөөдөртэй харьцуулахад Монголыг сонирхох стратегийн ба эдийн засгийн сонирхлын агуулга үндсэндээ хэвээрээ. Ялгаа нь орчин үед бол илүү олон талын, бас дэлхийн худалдаа, эдийн засгийн даяарчлалын үйл явцын шинж төрхөөр тодорхойлогдож байна.

Харин ХХ зууны эхэн үед Монголын стратегийн ба эдийн засгийн хүчин зүйлүүд Манж Чин улсад олонхи болж байсан хятадын худалдаа, цэргийнхэн төдийгүй, хаант Орос улсын сонирхлыг татаж байсан нь “Монголын асуудлыг” олон улсын түвшинд авч үзэж, шинээр хандах шалтгаан болсон юм. Монголын тусгаар тогтнолын асуудал хэдийгээр тэр даруй биш ч гэсэн эцсийн дүндээ монголчуудад эерэгээр шийдэгдсэн юм. Хүн ам цөөн боловч олон сая мал нь Монголыг том гүрний түвшний худалдаа эрхлэх боломж олгож байв. Ийм ч учраас мал, мал аж ахуйн гаралтай худалдааны ачаар Монгол нь бүр өнгөрсөн зуунд хоёр хөршийн төдийгүй, том гүрнүүдийн өөрөөр хэлбэл, дэлхийн худалдааны сүлжээнд хэдийнээ хамрагдсан байжээ.

\*Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Дэлхийн том гүрнүүд Азид нэвтрэх тусам Манж Чин улс капиталист харилцаанд татагдан орж эдийн засаг, худалдааны шинэ харилцаа Монголд ч нэвтэрч эхлэв. Манж Чин улсын хүчин чадал доройтох тусам Хятадын санхүү, худалдаа, цэргийнхэний үйл ажиллагаа Монголд хүчтэй болжээ.

Монгол нь хөгжлийн хувьд дорой ч хятадын худалдаачдын хувьд ашигтай зах зээл байлаа. Нэгэн үе тэд монголын зах зээл дээр дангаараа ноёрхож байв. Монгол дахь Оросын анхны консул Я.П. Шишмаревын “Өргөө дахь Консулын 25 жилийн үйл ажиллагааны тухай” 1886 оны 2 сарын 27-нд бичсэн тайлангаас харахад Монголд нийт 400 шахам хятад худалдаачдын пүүс ажиллаж байв. Тэдгээрээс Даашинхүү, Тянь-шень ба Юань Зай зэрэг гурван гол компани нийт Монголын нутгийг хамарсан худалдаа эрхэлж, мал, мал аж ахуйн түүхий эд, ангийн үсний худалдааг хянаж байв. Я.П.Шишмаревын тооцоолсноор Их Хүрээ, Зүүн ба Баруун Монголоос жилд 3 сая 115 мянган толгой мал, хонины арьс - 1 сая 350 мянгыг Хятад руу гаргаж байв. Хятадын Армид адуу нийлүүлж байсан ба 1 адуу 8 лан мөнгө болж байжээ. Хятадуудын өөрсдийнх нь үнэлснээр Монгол дахь худалдаа нь нэг үе 60-100 хувийн ашигтай байжээ. (1) Монгол дахь хятадын худалдаачид 36 хувиар мөнгө хүүлж байв. Жишээлбэл Даашинхүүгийн пүүс зөвхөн мөнгө зээлдүүлсэний хүүд жил бүр 500 мянган хонь, 70 мянган адуу Хятад руу гаргаж байв. Монголын Хойд хэсэгт нэгэн орос худалдаачны тооцоолсноор 5,35 сая га газрыг хятадууд эзэмшиж байжээ. (2)

1860-аад оноос Хаант Оросын Монгол дахь эдийн засгийн ашиг сонирхол тодорч, Бээжингийн Гэрээгээр Оросын худалдаачдыг Хиагт, Хүрээ, Жанчхүү-д худалдаа хийх, Хүрээнд Консулын газар байгуулахыг зөвшөөрчээ. (3) Ийнхүү Монгол нь мал аж ахуйн хямд түүхий эдийн зах зээлийн хувьд хоёр хөршийн худалдаачдын өрсөлдөөний талбар болов. Тэд Монголоос ноос, ноолуур, тарваганы арьс, ангийн үс худалдан авч, малыг амьдаар нь гаргаж байв. Ноосыг газар дээр нь цэвэрлэж тээвэрлэх зорилгоор ноос угаах газар байгуулж 1910 он гэхэд тэдгээрийн тоо 100 шахам болсон байв. (4) 1908 онд 1 сая 100 мянга гаруй толгой мал Орос руу гаргажээ. Харин Хятадын худалдаачид мал сүргийг монголчуудаар маллуулж төлөөр нь өсгөж авдаг байв.

ХИХ зууны сүүлч үеэс эхлэн Хятад, Оросоор дамжин Өрнөдийн худалдаа, санхүү, аж үйлдвэрийн салбарын капитал Монголд нэвтэрч эхлэв. Энэхүү үйл явц хэд хэдэн үе шаттай хөгжсөн байна.

**Нэгдүгээрт**, 1870-аад оноос Англи, Герман, Америкийн санхүү, худалдааны бүлгийнхэн Хятадаар дамжуулж Монголтой худалдаа хийж эхэлжээ. 1870-аад онд Хөх хотод Өрнөд Европын худалдааны 29 пүүс байсан байна. Тэдгээрээс томоохон нь Garden, W. Forbes and Co, A. Meyer and Co, Pettek, Macly, Halch and Co зэрэг байв. Монголоос худалдан авч байсан бараа гэвэл мал, малын арьс шир, ноос, ноолуур, ангийн үс зэрэг байжээ. Жишээлбэл, Грезель хэмээх герман хүн Collins and Co-гийн нэрийн өмнөөс Говийн аймгуудаас жилд 10 пүү ноос цуглуулж байв. (5)

Өрнөд Европын орнуудаас Хятадын Тяньзинь хүртэл далайн тээврээр тээвэрлэж, улмаар Чуулалт Хаалгаар дамжуулж их хэмжээний бараа, жишээлбэл, англи, америкийн дрилинг буюу даалимба, францын оргилуун дарс, германы ноосон даавууг Монголд худалдаж байв. Хятад цайны дараа Монголд нэн гүйлгээтэй бараа бол даалимба, мөн америк янжуур байжээ. Монголчуудын өргөн хэрэглээний бараа болох даалимбыг тээвэрлэж байсан түүх сонин ажээ. Алс холын Америкийн Алабама, Техас зэрэг Өмнөд нутагт тариалсан хөвөнг хурааж, анхан шатны боловсруулалт хийсний дараа Английн Манчестер зэрэг сүлжмэлийн үйлдвэрүүдэд нийлүүлж, тэндээс Хятадын Тяньзинь боомтонд хятадын гар урчууд монголын ба Азийн бусад улс орны хэрэглэгчдэд зориулан будаж, Чуулалт Хаалгаар дамжуулж Монголд худалдаж байв. Тэр үед хөвөн бөс бараа америкийн экспортын 50-60 хувийг бүрдүүлж байсан ба дэлхийн зах зээл дээр гол нийлүүлэгч улс байжээ. (6)

**Хоёрдугаарт**, ХХ зууны эхэн үеэс Өрнөд Европын пүүс, компаниуд Хятад, Оросын зуучлалгүй Монголд шууд нээгдэж ажиллаж эхлэв. Германы капиталыг төлөөлсөн Стүкен нарын Ко 1904 оноос, 1907 онд анх Английн, улмаар Америк, Германы фирмүүд байгуулагджээ. 1909 оноос Их Хүрээнд Бидерманы пүүс ажиллах болов. (7) Английн худалдаачид Монголтой хятадын зуучлалгүй шууд харилцахыг ч эрмэлзэж байв. Жишээлбэл, 1906 онд Английн Ах дүү Рейхарт фирмынхан монголчуудтай шууд харилцаж ноос худалдаж авах хүсэлтэй байжээ. Мөн Тяньзинь хот дахь английн “Forbers and C” “Wilson and C” компанийн хятад төлөөлөгчид Хүрээнд ажиллаж байв.

**Гуравдугаарт,** Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа 1911 оноос хойш Монгол дахь Өрнөдийн орнуудын бизнесийн үйл ажиллагаа мэдэгдэхүйц идэвхжив. 1915 онд Чуулалт Хаалганд гадаадын 20 пүүс ажиллаж байсан ба тэдний ихэнх нь Монголтой худалдаа эрхэлж байжээ. Гадаадын бизнесменүүдийн Монголд хувиараа бизнес эрхлэх сонирхол ч нэмэгдэж байв. Жишээлбэл 1913-1915 онд Грек, Австри, Герман, Оросын иргэд Их Хүрээнд бизнес эрхэлж байсан ба улмаар Англи, Австри, Норвег, Туркийн иргэд Их Хүрээнд худалдааны пүүс нээх зөвшөөрөл авч байжээ. (8)

Гадаадын капитал өөр хоорондоо хүчтэй өрсөлдөж байв. Хаант Оросын засгийн газар Монгол дахь хятадын худалдаачдын талаар өргөн дэлгэр мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийж байсныг Оросын анхны консул Я.П.Шишмаревын тайлангаас тодорхой харж болно. Европын бусад улс ч Оросын жишгээр Монголыг сонирхох сонирхол нь нэмэгдэж байв. Жишээлбэл 1914 оны 4-р сарын 18-нд Петербург дахь өөрийн Элчин сайд Лорд Бьюкээр дамжуулж Монголд Оросын иргэдийн эдэлж байгаа шиг таатай нөхцлийг англи иргэдэд эдлүүлэх, гадаад Монголыг улам нээлттэй болгохыг шаардаж байжээ. (9)

Франц зэрэг Европын бусад улс ч Монголтой худалдаа хийх боломжийг судлах болжээ. 1914-1916 онд Орост сууж байсан Францын Элчин сайд Палеолог Монголын улс төрийн байдал, эдийн засаг, худалдаа, монгол, оросын худалдааны харилцааг нарийвчлан судалж төвдөө дэлгэрэнгүй тайлан гаргаж байв. 1914 оны 5-р сарын 31-нд БНФУ-ын Гадаад хэргийн сайдад илгээсэн бичигтээ “Монголын худалдан авах чадварыг 550 сая франк гэж үнэлээд үүнд Монголын талын худалдааных - 220 сая орчим” гэжээ. (10) Мөн 1916 оны 4-р сарын 12-нд Францын ГЯЯ-ны сайд Бриан-д илгээсэн бичигтээ Манжуур, Сибирь, Монголын эдийн засгийн нөөцийн талаар бичээд “Омск, Эрхүү, Красноярск зэрэг Сибирийн аль нэг хотод консулын газар байгуулах” санал тавиад Омскт Герман, Англи, Дани, Швед улс консулын газар байгуулсан тухай дурьджээ. (11) 1916 оны 5-р сарын 2-нд төвөөс нь хариу ирж түүний саналыг “улс төрийн ба эдийн засгийн ач холбогдолтой” гээд нарийвчлан судлахыг даалгаж байв. (12)

1915-1921 онд Монгол дахь Америкийн худалдааны эрх ашиг, сонирхол тодорч эхлэв. 1919 онд Хаалганд Америкийн 5 компани, Нийслэл Хүрээнд 2 компани ажиллаж байв. Андерсен ба Мейер компани жилдээ 4 мянга шахам адууг Хятад руу гаргаж байв.

Уралдааны морьдыг Бээжин, Тяньзинь, Шанхайн морин тойруулга дээр зарж байв. Mongolian Trading Company бол Хүрээ-Хаалган чиглэлд сард гурван удаа автотээвэр хийдэг, Монголоос малын арьс шир, ангийн үс экспортолж байжээ. Тус компанийн ажилтан А. Гуптеллын (герман үндэстэн) Америкийн албаны хүнээр Вашингтонд илгээсэн захидалд: Монголд америкийн байгууллагын хийж байгаа худалдаа жилд 2 сая ам.дол.-т хүрдэг тухай дурьдаад Монголоос ангийн үс худалдаж авах нь ашигтай тухай бичиж байжээ. (13) 1921 оны 8-р сард Хаалган дахь америкийн консул С.Сокобин Нийслэл Хүрээнд ирэхдээ америкийн компаниудад алтны уурхайд ажиллах зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг Ерөнхий сайд Бодоод тавьж нааштай хариу авч байжээ.

Хаант Орос улс, Франц ба Европын бусад орны капитал алт олборлох чиглэлээр Монголд нэвтэрч байсан нь тухайн үеийн дэлхийн эдийн засгийн хөгжил, хандлагатай холбоотой юм.

Франц, Герман зэрэг Европын хүчирхэг улсууд Монголд өндөр ашигтай салбар болох алтны уурхайд хөрөнгө оруулсан нь тухайн үеийн санхүү эдийн засгийн нөхцөл байдалтай салшгүй холбоотой байжээ. Тэр үед дэлхийн тэргүүлэх улс орнуудад эдийн засаг, санхүүгийн хүчин чадлаа мөнгө ба алтаар баталгаажуулах журам хэвшиж байсан чухам тэр үед Монголд алт олборлож эхэлжээ. 1895 онд Петербург дэх олон улсын банкны санаачилгаар Орос, Хятадын банк байгуулагдсан ба мөн онд Оросын анхны хувь нийлүүлсэн “Золоторосс” хэмээх үйлдвэр байгуулагдаж, аль алинд нь францын капитал оролцжээ. Банкны наймны таван хувь нь францынх, наймны гурван хувь нь германых байжээ. (14) “Золоторосс” үйлдвэрийн хөрөнгийн 40 хувийг Франц, 60 хувийг оросууд эзэмшдэг байв.

1900 онд Чин улсын гадаад хэргийн өндөр албан тушаалтан Ли Хун Жаны хувийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Оросын иргэн В.Ю.фон Грот гэгч Монголд концесс эзэмших зөвшөөрлийг Бээжингээс авч, улмаар Санкт-Петербургт Түшээт хан, Цэцэн хан аймагт уул уурхайн ажил эрхлэх хувь нийлүүлсэн нийгэмлэг буюу “Монгол-ор” хэмээх үйлдвэрийг 1.8 сая рублийн хөрөнгөтэйгээр байгуулжээ. Үндсэн хувь нийлүүлэгчид нь Оросын Хатан хаан Мария Федоровна, Бельгийн хаан Леопольд II ба Ли Хун Жан, Орос, францын хувь нийлүүлсэн “Золоторосс” нийгэмлэг, “Мендельсон Ко” хэмээх германы компани, Санкт-Петербургийн олон улсын банк, Франц-нидерландын хамтарсан банк, Хятад, америкийн синдикат хөрөнгө

оруулжээ. Уурхайн төлөөлөн удирдах зөвлөлд Францын баян Ротшильдын хүргэн Ротштейн, Бельгийн санхүү-үйлдвэрийн эзэн Браун де Тьеж, Орос-хятадын банкны ерөнхий хорооны дарга Е. Ухтомский, Бээжин дэх Оросын сангийн яамны төлөөлөгч Д. Покотилов нар орсон ба В. Ю. Грот гүйцэтгэх захирлаар ажиллаж байв. Гэрээг Оросын санхүүгийн сайд С. Ю. Витте бэлдсэнээс харахад уг уурхай өндөр ашигтай байсан нь ойлгомжтой. Ер нь Ерөөгийн алтны уурхайг оросууд хоердахь Лена гэж нэрлэж байв. Геолог хайгуулын ажлыг АНУ-аас урьж авчирсан дөчөөд инженер, техникийн мэргэжилтэн гүйцэтгэжээ. Тиймээс Монгол дахь алтны нөөцийн талаар тодорхой мэдээлэлтэй байсан учраас америкийн албаны хүмүүс Монголд алт олборлох зөвшөөрөл олж авах тухай ярилцаж байсан биз ээ. Тэр үед АНУ нь эдийн засаг, санхүүгийн тогтолцоогоо алтаар баталгаажуулах талаар Европын орнуудаас хоцорч байснаас эдийн засагт нь сөргөөр нөлөөлсөн гэж мэргэжилтнүүд үздэг ажээ.

Монгол-ор нь 1900-1919 онд ажилласан ба өндөр ашигтай байжээ. Зөвхөн 1910 онд 120 пүү алт олборлосон мэдээ байдаг. Олборлосон алтыг Петербург, Гамбург, Амстердам, Парис хот руу аваачиж борлуулж байв. (15) Нийт алт олборлолтын хэмжээг нуун дарагдуулж байсан учраас тоо нилээд зөрүүтэй байдаг бөгөөд жилд ойролцоогоор 100 гаруй пүү алт олборлож байсан тухай судлаачид бичсэн байдаг. (16) Олборлох алтны 15 хувийг хятадын засгийн газарт төлөх болзолтой байжээ. Франц, Орос гээд Европынхон Монголд алт олборлож байсан чухам энэ үед буюу 1850-1890-ээд онд Америкт Калифорни, Колорадо, Клондаик зэрэг газар алт олборлох өргөн хөдөлгөөн гарсан бөгөөд үүний ч ачаар эзгүй хээр байсан тэдгээр нутагт хожим америкийн том том хотууд сүндэрлэн боссон билээ. Харин Монголын хувьд хэзээнээс алтны баялаг нөөцтэй ч, харийн гүрний эзэмшилд байсан учраас монголчууд газрын баялгийнхаа үр шимийг огтхон ч хүртэж чадаагүй юм. Харин Монгол тусгаар тогтнолоо зарласны дараа ба автономитын үед Монголын засгийн газар уурхай ашигласны түрээсэнд олборлолтын 16,5 хувийг авахаар тохиролцож концессийн хугацааг 1931 он хүртэл сунгаж байв. Гэвч энэ үед ч Монголын засгийн газарт төлөх төлбөрөөс зайлсхийж олборлолтын хэмжээг нуун дарагдуулж байжээ.

“Монгол-ор”-ын 22 уурхайд 10 гаруй мянган хятадууд ажилладаг байсан ба харин 1921 оны хувьсгалын өмнөхөн ажиллагсадын тоо 2665 болжээ. 70 нь монголчууд байжээ. Уурхайд

оролцогчдын эрх ашгийн зөрчил хүчтэй байсны нэг тод жишээ бол Орост хаант засаг унаж Петроградтай холбоо тасарсны дараа уурхайн бүх эрх мэдлийг Фитингоф гэгч ганцаараа мэдэж байсан ба 1920-иод оны сүүлчээр зургаан машин хөлөглөсөн америкчууд ирж Фитингофыг Бээжинд аваачиж “Монгол-ор”-ын концессийн эрхийг америкийн нэгэн компанид шилжүүлэх тухай яригдаж байсан тухай баримт байдаг ажээ.

Монголын нийт худалдааны эргэлт өндөр үзүүлэлттэй байжээ. Бээжинд сууж байсан Америкийн худалдааны атташе Жулиан Арнолдын 1915 онд Вашингтон руу илгээсэн тайланд дурьдсанаар Монголын нийт экспорт 15 сая ам.долларт хүрч байсан байна. (17) Энэ нь тухайн үеийн улс орнуудын дундаж үзүүлэлт юм. 1800-аад онд Америкийн нийт экспорт жишээлбэл, 22 сая ам.дол.байжээ. Монголтой харилцаж худалдаа хийж, алтны уурхай ажилуулж байсан гадаадынхан өндөр ашиг олддог байжээ.

Харийн колоничлол дор байсан учраас мал сүрэг, алт баялгийнхаа үр шимийг монголчууд өөрсдөө бүрэн дүүрэн хүртэж чадаагүй билээ. Гэлээ ч чухам тэр үеэс, ялангуяа 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа колоничлолын үеийн түгжигдмэл байдлаасаа ангижирч, нийгэм нь нээлттэй болж, худалдаачид, гар урчууд, жижиг үйлдвэрлэгчид гээд нийгмийн цоо шинэ давхарга бий болсон ба хожим чухам тэр давхарга монголын нийгмийг орчин цагийн журмаар өөрчлөн шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Түүнчилэн тэр жилүүдэд гадаадын худалдаа, үйлдвэрлэлийнхэнтэй хамтран ажиллах анхны туршлага хуримтлуулжээ.

**Ишлэл зүүлт**

1. Русский консул в Монголии, Отчет Я.П.Шишмарева о 25-летней деятельности Ургинского консульства, Иркутск, 2001, с. 82-84, 95- 99
2. J. Legrand, Le Choix Mongol, Paris, 1975, p.58
3. Орос-Хятадын Гэрээ, Хэлэлцээрүүдийн эмхтгэл, Нэгдүгээр хэсэг (1689-1949), УБ, 2001, х. 47
4. Ч.Баянжаргал Монголын эдийн засгийн түүх, УБ, 2001, х. 91
5. Русский консул в Монголии, Отчет Я.П.Шишмарева о 25-летней деятельности Ургинского консульства, Иркутск, 2001, с.9
6. The Reader's Companion to American History, Boston, 1991, p. 992)
7. Ч.Баянжаргал Монголын эдийн засгийн түүх, УБ, 2001, х. 90
8. Х.Ж.Урангуа, XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа, Түүх, МУИС, эрдэм шинжилгээний бичиг, 2002, №188, х.26-27
9. мөн тэнд
10. Гадаад харилцааны Архив, Ф- 34, ХН- 175, х. 237
11. Гадаад харилцааны Архив, Ф-34, ХН-175, х. 276
12. Гадаад харилцааны Архив, Ф- 34, ХН- 175, х. 279
13. Alicia J. Campi, Early U.S. - Mongolian Diplomatic Contacts, Mongolia Survey, Number six, 1999, p. 49-51
14. Д.Уламбаяр, Монгол-Францын харилцааны ойрхи үеийн түүхэн тэмдэглэл, Олон улсын харилцаа, 2002, №1, х.30
15. Ч.Баянжаргал Монголын эдийн засгийн түүх, УБ, 2001, х. 94
16. J. Legrand, Le Choix Mongol, Paris, 1975, p.64
17. Alicia J. Campi, Early U.S. - Mongolian Diplomatic Contacts, Mongolia Survey, Number six, 1999, p. 49